



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2023 оны I улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	7
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	7
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт.....	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид.....	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгөн хөрөнгө.....	12
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	12
Факторингийн тооцооны авлага.....	13
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө	13
Зээл.....	14
Цахим зээл.....	16
Ногоон зээл	17
Бусад хөрөнгө	18
Эргэлтийн бус хөрөнгө	18
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	19
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	20
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	20
Бусад эх үүсвэр	21
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	21
Төслийн зээлийн санхүүжилт.....	22
Бусад өр төлбөр	23
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	23
Бусад өмч, сангууд	24
Хуримтлагдсан ашиг	24
Хоёрдогч өглөг.....	25
Ашигт ажиллагаа	25
Гадаад валютын арилжааны мэдээ	27
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	28
Дүгнэлт	29
Актив, пассивын бүтэц.....	29
Ашигт ажиллагаа	29
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	30

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 5 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл	9
Хүснэгт 6 Статистик мэдээлэл /5 жилээр/	9
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа	10
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 12 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	12
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	12
Хүснэгт 16 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 17 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 18 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 19 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	14
Хүснэгт 20 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/	15
Хүснэгт 21 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/	16
Хүснэгт 22 Зээлийн ангилал	16
Хүснэгт 23 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд	16
Хүснэгт 24 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/	17
Хүснэгт 25 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/	18
Хүснэгт 26 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	18
Хүснэгт 27 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	19
Хүснэгт 28 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/	20
Хүснэгт 30 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/	21
Хүснэгт 31 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/	21
Хүснэгт 33 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/	21
Хүснэгт 34 Өрийн бичиг /валютаар/	22
Хүснэгт 36 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/	22
Хүснэгт 37 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/	23
Хүснэгт 38 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/	23
Хүснэгт 39 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	24
Хүснэгт 40 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	24
Хүснэгт 41 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/	24
Хүснэгт 43 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/	25
Хүснэгт 44 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	26
Хүснэгт 45 2023 оны I улирлын байдлаарх валют арилжааны мэдээ /тэрбум төгрөгөөр/ ...	27
Хүснэгт 46 Гадаад валютын арилжааны мэдээ /2023 оны I улирал/	27
Хүснэгт 47 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/	28

Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	11
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	12
Зураг 5 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	14
Зураг 6 Зээлийн багцын чанар /хувиар/	14
Зураг 7 Олгосон зээл /хугацааны ангиллаар/	15
Зураг 8 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/	18

Зураг 9 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	19
Зураг 10 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	20
Зураг 11 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	20
Зураг 12 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/	21
Зураг 13 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	22
Зураг 14 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	23
Зураг 15 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	25

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2023 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 514 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 15 ББСБ буюу 2.8 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 94 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 25 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2019-I	2020-I	2021-I	2022-I	2023-I
Шинээр олгосон	3	3	1	6	6
Хүчингүй	3	1	3	11	5
Түдгэлзүүлсэн	4	18	-	4	1
Сэргээсэн	4	1	5	5	10
Нийт ББСБ	539	540	530	529	514
Үүнээс: ХОН	77	75	76	85	94
Үүнээс: ГХО	27	28	30	28	25
Салбар	220	273	298	393	428
Төлөөлөгч	5	9	8	8	7

2023 оны I улирлын байдлаар 6 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 5 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 1 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 10 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2023 оны I улирлын байдлаар 39 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2022-I	2023-I	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	2,972.8	3,702.1	24.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	7.4%	8.0%	0.6%
Нийт өөрийн хөрөнгө	1,864.3	2,316.3	24.2%
Банкны салбартай харьцуулахад хувиар	50.2%	51.5%	1.3%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,164.6	1,361.1	16.9%
Банкны салбартай харьцуулахад хувиар	75.2%	84.1%	8.9%
Нийт зээл	2,293.6	2,864.0	24.9%
Банкны салбартай харьцуулахад хувиар	10.2%	12.2%	2.0%
Нийт орлого	184.4	258.5	40.2%
Нийт зарлага	105.8	159.0	50.3%
Цэвэр ашиг	78.6	99.6	26.6%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар өсөж, банкны салбарын 8.0%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 84.1%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.9 пунктээр өссөн дүн юм.

2023 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар буюу 729.2 тэрбум төгрөгөөр өсөж 3.7 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 78.2 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 38.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 62.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 40.2 хувиар буюу 74.2 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 50.3 хувиар буюу 53.2 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 26.6 хувиар буюу 20.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2022-I	2023-I	тоо	хувь
	Нийт ББСБ-ын тоо	529	514	(15)	-2.8%
1	Зээл	492	477	(15)	-3.0%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	321	305	(16)	-5.0%
2	Факторинг	41	47	6	14.6%
3	Төлбөрийн баталгаа гаргах	27	28	1	3.7%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	5	-	0.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	38	40	2	5.3%
6	Гадаад валютын арилжаа	144	139	(5)	-3.5%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	37	36	(1)	-2.7%
7	Итгэлцэл	52	69	17	32.7%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	21	24	3	14.3%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	42	-	-	-
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	1	1	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 514 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 93.2% нь буюу 477 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 59.3% нь буюу 305 ББСБ дагнан

эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 139 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 27.0 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 36 ББСБ нийт ББСБ-уудын 7.0 хувийг бүрдүүлж байна.

Зээл болон гадаад валют арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс харгалзан 5.0 хувь, 2.7 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл итгэлцлийн үйлчилгээ 32.7 хувиар, факторинг 14.6 хувиар, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 14.3 хувиар тус тус өссөн байна. Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 669 дүгээр тогтоолоор нэр бүхий 39 ББСБ-ын хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосон ба 2023 оны I улирлын байдлаар 25 ББСБ тусгай зөвшөөрлөө хүчингүй болгосон тухай өөрчлөлтөө улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгүүлсэн байна.

2023 оны I улирлын тайлан мэдээний ирц 99.0% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 514 ББСБ-аас 509 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 4 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 1 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Өмнөх улирлын байдлаар нэгтгэлд хамрагдсан 4 ББСБ-аас 2 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлэх арга хэмжээг Хяналт шалгалт зохицуулалтын газраас авч хэрэгжүүлсэн байна.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

- “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-д Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамд 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/283 тоот албан бичгээр өөрчлөлтийг хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- 2023 оны I улиралд 13 ББСБ-аас финтек зээлийн бүтээгдэхүүн бүртгүүлэхээр хүсэлт ирүүлснээс 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Цахим зөвлөлийн анхны хуралдаанаар журмын шаардлага хангасан 7 ББСБ-ыг [Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд](#) бүртгэсэн байна. Финтек зээлийн үйлчилгээний эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор цахим зээл олгож байгаа ББСБ-уудыг 2023 оны 6 сарын 30-ны өдрийн дотор журамд заасан шаардлагыг ханган бүртгүүлэх хугацаа өгсөн бол шинээр финтек зээлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ууд нь журмын шаардлагыг ханган, бүртгүүлэх хүсэлтээ ирүүлэх боломжтой. Журам батлагдсанаас хойш зөвшөөрөлгүй финтек зээлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ-уудад журамд заасан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 498 дугаар тушаалаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцүүлэн холбогдох дүрэм, журам, зааврыг боловсруулах, судалгаа шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулсан бөгөөд СЗХ-ны 2023.03.13-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн

бүртгэл, үйл ажиллагааны журам”, 82 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан мэдээ ирүүлэх журам”, 83 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох”, 84 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”, 85 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 6484-6488](#) тоот дугаарт бүртгүүллээ.

- Банкны тухай хуулийн 6.2-т заасны дагуу 2 банканд факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олголоо. 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор Хаан банканд, 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 97 дугаар тогтоолоор Худалдаа хөгжлийн банканд тус тус олгосон байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2023 оны I улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2023 оны I улирлын санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 85.4 хувь буюу 434 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 80.5 хувь буюу 409 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч

байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 477 ББСБ-ын 88.5% буюу 422 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А-264, А-265 дугаар тушаалаар Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК авсан. Ингэснээр 2022 оны 11 дүгээр сарын 01-ээс эхлэн Монголбанкны зээлийн мэдээллийн лавлагаа олгох үйл ажиллагаа зогсож дээрх 2 компаниудын үйл ажиллагаа эхэлж байна. Иймд ББСБ-ууд дээрх 2 компаниудтай гэрээгээ шинэчлэн байгуулж хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах шаардлагатай байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон

гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 90 ББСБ, 1262 удаагийн тохиолдлоор, 208.2 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 3 ББСБ, 8 удаагийн тохиолдлоор, 571.3 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2023 оны I улирлын байдлаар нийт 508 ББСБ-аас 1,259.4 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 72.5% буюу 353 ББСБ 912.6 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2023 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 28,353 хувьцаа эзэмшигчдийн 514 ББСБ, 428 салбар нэгж, 7 төлөөлөгчийн газар, 4,735 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.9 сая харилцагч, 1.3 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар буурч давхардсан тоогоор 3,862,489-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар буурч 1,297,025-г хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	3,862,489	3,316,297	221,118	3,633,085	20,240	3,839,993	22,496	417,397	123,306
Үүнээс: Эмэгтэй	2,097,287	1,799,843	113,011	1,979,546	8,677	2,084,847	12,440	219,791	65,780
Эрэгтэй	1,760,654	1,515,675	104,190	1,652,909	9,000	1,750,654	10,000	197,265	57,240
Хуулийн этгээд	4,548	779	3,917	630	2,563	4,492	56	341	286
Итгэмжлэгчдийн тоо	7,087	7,086	2,117	4,970	-	7,083	4	2,609	295
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,615	1,555	169	1,446	-	1,598	17	1,114	353
Зээлдэгчдийн тоо	1,297,025	779,156	191,296	1,097,443	-	1,274,575	22,450	209,786	123,306
Хэвийн	1,108,186	648,036	161,099	939,559	-	1,090,235	17,951	172,852	100,311
Хугацаа хэтэрсэн	60,099	37,987	9,797	50,145	-	58,277	1,822	10,566	5,297
Чанаргүй:	128,740	93,133	20,400	107,739	-	126,063	2,677	26,368	17,698
-Хэвийн бус	35,024	22,882	5,431	29,377	-	33,945	1,079	7,585	4,548
-Эргэлзээтэй	44,797	30,678	4,539	40,044	-	44,294	503	8,875	6,243
-Муу	48,919	39,573	10,430	38,318	-	47,824	1,095	9,908	6,907
Зээлдэгчдийн насжилт	1,295,354	778,498	190,140	1,096,929	-	1,272,959	22,395	209,561	123,020
18-35 насны	793,522	447,888	80,473	709,525	-	782,902	10,620	123,895	74,157
36-45 насны	314,657	203,916	61,184	250,076	-	308,050	6,607	53,621	30,200
46-55 насны	144,895	91,925	35,529	108,108	-	141,265	3,630	24,758	14,857
55-аас дээш	42,280	34,769	12,954	29,220	-	40,742	1,538	7,287	3,806
Зээлдэгчдийн боловсрол	1,295,354	778,498	190,140	1,096,929	-	1,272,959	22,395	209,561	123,020
-Дээд	698,871	480,891	101,222	594,709	-	687,238	11,633	126,412	78,212
-Тусгай дунд	98,089	62,149	16,828	79,767	-	95,450	2,639	24,694	18,931
-Бүрэн дунд	340,078	171,337	61,347	276,215	-	333,179	6,899	46,234	19,730
-Дунд	111,881	58,822	6,837	104,122	-	111,021	860	10,472	5,588
-Бага	46,435	5,299	3,906	42,116	-	46,071	364	1,749	559

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Нийт харилцагчдын 94.1% буюу 3,633,085 нь, зээлдэгчдийн 84.6% буюу 1,097,443 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 5.7% буюу 221,118 нь, зээлдэгчдийн 14.7% буюу 191,296 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 20,240 буюу нийт харилцагчдын 0.5 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2019-I	2020-I	2021-I	2022-I	2023-I	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	7,207	8,104	17,339	21,788	28,353	6,565	30.1%
Ажилчдын тоо	2,820	3,168	3,517	4,322	4,735	413	9.6%
Харилцагчдын тоо	1,664,902	2,203,682	3,481,431	4,645,134	3,862,489	-782,645	-16.8%
Зээлдэгчдийн тоо	263,949	425,859	610,068	1,453,685	1,297,025	-156,660	-10.8%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.4%	3.0%	2.9%	3.1%	3.1%	-	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 30.1 хувиар буюу 6,565-гаар өсөж 28,353-д хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 96.4 хувь буюу 27,332 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,021 буюу 3.6% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 2,606 буюу 9.2% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 212 буюу 0.7% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	28,353	27,505	1,855	26,497	54	28,141	212	27,332	2,606
Нийт ажилтнуудын тоо	4,735	2,549	2,602	2,130	100	4,470	265	396	423
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	2,794	1,477	1,578	1,214	55	2,613	181	243	247
Эрэгтэй ажилтны тоо	1,941	1,072	1,024	916	45	1,857	84	153	176

Хөдөө орон нутгийн 94 ББСБ 6 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	514	69	474	39	36	420	94	5	509	25
1 Зээл	477	69	437	39	-	385	92	5	472	25
2 Факторингийн үйлчилгээ	47	22	31	15	-	47	-	3	44	2
3 Төлбөрийн баталгаа гаргах	28	14	21	7	-	27	1	2	26	5
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	3	1	4	-	5	-	1	4	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	40	21	27	13	-	39	1	3	37	1
6 Гадаад валютын арилжаа	139	32	124	15	36	129	10	4	135	7
7 Итгэлцлийн үйлчилгээ	69	69	49	20	-	68	1	5	64	7
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	24	16	16	8	-	22	2	2	22	4
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 81.7% буюу 420 ББСБ, салбаруудын 63.6% буюу 272 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 18.3% буюу 94 ББСБ, салбаруудын 36.4% буюу 156 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2023 оны I улирлын байдлаар 94 ББСБ-ын 428 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 61.8 хувийг 13 ББСБ-ын 264 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	420	272	692	100.0%
Сүхбаатар дүүрэг	139	41	180	26.0%
Чингэлтэй дүүрэг	115	39	154	22.3%
Баянгол дүүрэг	71	41	112	16.2%
Баянзүрх дүүрэг	46	65	111	16.0%
Хан-Уул дүүрэг	39	32	71	10.3%
Сонгинохайрхан дүүрэг	9	47	56	8.1%
Багануур дүүрэг	1	4	5	0.7%
Налайх дүүрэг	-	3	3	0.4%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, Өвөрхангай аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	94	156	250	100%
Архангай аймаг	3	6	9	3.6%
Баян-Өлгий аймаг	3	4	7	2.8%
Баянхонгор аймаг	5	7	12	4.8%
Булган аймаг	2	1	3	1.2%
Говь-Алтай аймаг	1	1	2	0.8%
Говьсүмбэр аймаг	2	3	5	2.0%
Дархан-Уул аймаг	8	13	21	8.4%
Дорноговь аймаг	1	8	9	3.6%
Дорнод аймаг	5	13	18	7.2%
Дундговь аймаг	-	4	4	1.6%
Завхан аймаг	2	4	6	2.4%
Орхон аймаг	10	16	26	10.4%
Өвөрхангай аймаг	10	12	22	8.8%
Өмнөговь аймаг	2	14	16	6.4%
Сүхбаатар аймаг	6	6	12	4.8%
Сэлэнгэ аймаг	6	11	17	6.8%
Төв аймаг	17	4	21	8.4%
Увс аймаг	4	8	12	4.8%
Ховд аймаг	1	5	6	2.4%
Хөвсгөл аймаг	3	8	11	4.4%
Хэнтий аймаг	3	8	11	4.4%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2023 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 3.7 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.5 хувиар буюу 729.2 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 78.2 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2022-I дүн	Нийт дүнд эзлэх хувь	2023-I дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
<i>Эргэлтийн хөрөнгө</i>	2,874,556.1	96.7%	3,583,745.0	96.8%	709,189.0	24.7%
Мөнгөн хөрөнгө	374,225.1	12.6%	513,663.2	13.9%	139,438.1	37.3%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	19,793.8	0.7%	33,245.3	0.9%	13,451.5	68.0%
Зээл (цэврээр)	2,176,124.1	73.2%	2,698,572.6	72.9%	522,448.5	24.0%
<i>Нийт зээл</i>	2,293,590.4	77.2%	2,863,974.9	77.4%	570,384.5	24.9%
<i>(Зээлийн эрсдэлийн сан)</i>	117,466.3	4.0%	165,402.3	4.5%	47,935.9	40.8%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	9,019.2	0.3%	9,639.7	0.3%	620.4	6.9%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	16,289.9	0.5%	22,619.3	0.6%	6,329.4	38.9%
Бусад хөрөнгө	276,386.7	9.3%	306,005.0	8.3%	29,618.4	10.7%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага	2,715.8	-	0.0	0.0%	-2,715.8	-
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>	98,286.2	3.3%	118,332.7	3.2%	20,046.5	20.4%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	126,342.3	4.2%	152,069.3	4.1%	25,727.0	20.4%
(Хуримтлагдсан элэгдэл)	-28,056.0	-0.9%	-33,736.5	-0.9%	-5,680.5	20.2%
Нийт хөрөнгийн дүн	2,972,842.3	100.0%	3,702,077.8	100.0%	729,235.5	24.5%


2023 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 8.0 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 12.2 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2018 оны мөн үед 1,046.8 тэрбум төгрөг байсан бол 2023 оны I улирлын байдлаар 3.5 дахин өсөж 3.7 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 4.1 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 93.3% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 307 ББСБ, 4.4% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 175 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 2.2 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 132 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	2,817.6	109	76.1%	21.2%	9.4	1	6.3	1	5.3	1
2.5-5.0 тэрбум	638.0	198	17.2%	38.5%	6.4	2	5.6	2	2.6	1
1.9-2.5 тэрбум	163.9	75	4.4%	14.6%	-	-	4.4	2	-	-
1.4-1.9 тэрбум	27.7	17	0.7%	3.3%	4.4	3	6.3	4	-	-
0.6-1.4 тэрбум	27.8	29	0.7%	5.6%	8.8	10	9.5	10	5.7	6
0.6 тэрбум хүртэлх	27.0	86	0.7%	16.7%	-	-	16.4	58	10.6	28
НИЙТ	3,702.1	514	100.0%	100.0%	29.0	16	48.4	77	24.2	36

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 1.9 их наяд төгрөг байгаа нь нийт активын 50.7 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 1.5 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 53.1 хувийг бүрдүүлж байна.

Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 139.4 тэрбум төгрөгөөр буюу 37.3 хувиар өсөж 513.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 22.1% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 42.4% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 35.5% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	513.7	205.4	314.7	198.5	24.0	498.7	15.0	42.3	49.8
Бэлэн мөнгө	113.4	7.4	106.7	6.7	17.5	106.5	6.9	0.5	3.6
Харилцах	217.6	95.7	125.4	91.9	6.1	211.0	6.6	38.8	38.3
Хадгаламж	182.6	102.2	82.6	100.0	0.4	181.2	1.4	3.0	7.9

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 33.9%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 3.4%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 72.8% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 68.0% буюу 13.4 тэрбум төгрөгөөр өсөж, 2023 оны I улирлын байдлаар 29 ББСБ 33.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Богино хугацаат хөрөнгө оруулалтын 34.2% буюу 11.4 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас, 66.1% буюу 14.5 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 45.5% буюу 15.1 тэрбум төгрөг нь хувьцаа, 48.8% буюу 16.2 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 6.0% буюу 2.0 тэрбум төгрөг нь бусад үнэт цаасаар хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	33,245.3	23,286.2	5,147.3	28,097.9	1.0	32,469.1	776.2	16,660.0	14,303.3
Хувьцаа	15,129.2	13,581.1	2,926.4	12,202.8	1.0	14,354.0	775.3	10,615.5	8,929.8
Өрийн бичиг	16,236.0	7,836.0	400.0	15,836.0	-	16,236.0	-	5,903.3	5,394.9
Бусад	1,983.6	1,972.7	1,820.9	162.7	-	1,982.7	0.9	162.7	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	11,377.5	10,113.6	1,263.9	10,113.6	-	11,342.9	34.6	9,172.5	8,929.8
Арилжааны үнэт цаас	21,971.3	13,276.1	3,883.4	18,087.9	1.0	21,229.7	741.6	7,508.9	5,394.9

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 24 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 29 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 14 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт бүртгэсэн дүн байхгүй байна. Иймээс 15 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 6.9% буюу 620.4 сая төгрөгөөр өсөж, 14 ББСБ 9.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. 2023 оны I улирлын байдлаар 6 ББСБ 763.5 сая төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 147.8 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 9.6 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2022-I		2023-I		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	9,198.7	100.0%	9,787.4	100.0%		
Хэвийн	8,605.9	93.6%	9,023.9	92.2%	418.1	4.9%
Анхаарал хандуулах	206.4	2.2%	275.8	2.8%	69.4	33.6%
Чанаргүй	386.4	4.2%	487.6	5.0%	101.2	26.2%
Хэвийн бус	127.2	1.4%	293.3	3.0%	166.1	130.6%
Эргэлзээтэй	243.7	2.6%	182.0	1.9%	(61.7)	-25.3%
Муу	15.5	0.2%	12.3	0.1%	(3.2)	-20.9%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	179.5	2.0%	147.8	1.5%	(31.7)	-17.7%

Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч факторингийн тусгай зөвшөөрөлтэй 47 ББСБ-уудын 33 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь тул журамд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 6.3 тэрбум төгрөг буюу 38.9 хувиар өсөж 22.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	22,619.3	11,849.3	16,995.5	5,623.8	22,619.2	0.1	1,342.2	21,277.1	2,635.7
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	27,321.4	15,943.0	17,747.8	9,573.6	27,321.4	-	3,308.4	24,013.0	2,893.4
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	7,922.7	5,305.1	3,827.8	4,094.8	7,922.7	-	1,966.2	5,956.5	1,716.6
Өмчлөх бусад хөрөнгө	3,220.5	1,211.5	3,075.5	145.0	3,220.4	0.1	-	3,220.5	1,458.9

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.9% буюу 570.4 тэрбум төгрөгөөр өсөж 2023 оны I улирлын байдлаар 2,864.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 165.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,698.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	2,698.6	1,647.4	1,419.9	1,274.0	2,644.6	54.0	443.1	2,255.4	399.2
Нийт зээл	2,864.0	1,733.7	1,514.7	1,344.4	2,804.4	59.6	460.4	2,403.6	417.4
Хэвийн	2,510.0	1,541.9	1,320.7	1,185.1	2,458.2	51.8	414.6	2,095.4	372.3
Анхаарал хандуулах	125.9	76.7	63.9	61.9	124.4	1.6	20.8	105.1	19.4
Чанаргүй:	228.0	115.1	130.2	97.5	221.8	6.2	25.0	203.1	25.7
-Хэвийн бус	65.4	34.1	33.3	31.9	64.7	0.7	9.1	56.3	8.0
-Эргэлзээтэй	57.9	30.5	28.0	29.8	57.3	0.7	8.7	49.2	6.4
-Муу	104.7	50.6	68.9	35.8	99.9	4.8	7.2	97.5	11.3
(Зээлийн эрсдэлийн сан)	165.4	86.4	94.8	70.4	159.8	5.6	17.2	148.2	18.2
Нийт зээл (төгрөгийн)	2,780.5	1,666.7	1,499.1	1,276.6	2,721.3	59.3	428.0	2,352.5	381.3
Нийт зээл (валютын)	83.4	67.0	15.6	67.9	83.2	0.3	32.3	51.1	36.1
Зээлдэгчдийн тоо	1,297,025	779,156	191,296	1,097,443	1,274,575	22,450	209,786	1,087,239	123,306
- Иргэн	1,297,025	779,156	191,296	1,097,443	1,274,575	22,450	209,786	1,087,239	1,214,843
- Хуулийн этгээд	1,611	565	1,289	322	1,443	168	39	40	687

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/


Тайлант улиралд ББСБ-ууд 1.4 их наяд төгрөгийн зээлийг 3.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 1.3 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны I улирлын байдлаар 1,297,025 зээлдэгчийн 2.9 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Нийт зээлийн үлдэгдлийн 87.6 хувийг буюу 2.5 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4.4 хувийг буюу 125.9 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 8.0 хувийг буюу 228.0 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр буурсан бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.5, 0.4 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 353.9 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 46.7%-д буюу 165.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2023 оны I улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 12.4% байна.

Олгосон зээлийн 91.1% буюу 1.3 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 8.9% буюу 127.8 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 91.2% буюу 1.2 их наяд төгрөг нь иргэдээс, 8.8% нь буюу 113.0 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.


Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5,520.2	0.38%	5,976.0	0.46%	27,603.8	1.0%
2.	Уул уурхай, олборлолт	10,788.5	0.7%	10,265.9	0.8%	49,049.3	1.7%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	9,883.3	0.7%	9,284.0	0.7%	33,092.0	1.2%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1,747.4	0.1%	949.3	0.1%	5,908.8	0.2%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	549.8	0.0%	856.0	0.1%	1,693.9	0.1%
6.	Барилга	42,475.6	3.0%	43,213.5	3.3%	208,709.2	7.3%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	135,338.3	9.4%	124,806.2	9.7%	329,257.1	11.5%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	27,843.2	1.9%	26,487.6	2.1%	97,197.1	3.4%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	22,126.6	1.5%	9,370.9	0.7%	55,382.3	1.9%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	23,215.0	1.6%	17,429.4	1.3%	101,935.0	3.6%
11.	Мэдээлэл холбоо	3,569.9	0.2%	1,994.3	0.2%	10,164.1	0.4%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	39,517.1	2.7%	36,052.0	2.8%	53,889.1	1.9%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	11,692.0	0.8%	3,359.1	0.3%	27,689.8	1.0%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1,008.5	0.1%	2,006.0	0.2%	4,134.1	0.1%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4,395.5	0.3%	5,772.9	0.4%	19,834.1	0.7%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	278.4	0.0%	503.8	0.0%	1,772.8	0.1%
17.	Боловсрол	4,428.2	0.3%	3,967.4	0.3%	16,836.6	0.6%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	3,312.3	0.2%	3,334.4	0.3%	11,075.6	0.4%
19.	Бусад	1,091,381.7	75.8%	986,109.9	76.3%	1,808,750.1	63.2%
<i>Иргэнд олгосон зээл</i>		1,311,281.6	91.1%	1,178,699.6	91.2%	2,527,967.6	88.3%
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		127,789.9	8.9%	113,038.9	8.8%	336,007.2	11.7%
НИЙТ		1,439,071.5	100.0%	1,291,738.5	100.0%	2,863,974.9	100.0%

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 75.8% буюу 1.1 их наяд төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 9.4% буюу 135.3 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 76.3% буюу 986.1 тэрбум төгрөг нь бусад ангиллын зээлээс, 9.7% буюу 124.8 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангиллаар/

Тайлант улиралд олгосон 1.4 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 28.1 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 19.0 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 2.9 их наядын зээлийн 53.6 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 20.6 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 9.5 хувийг хуулийн этгээдийн бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 18 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	1,311.3	91.1%	1,178.7	91.2%	2,528.0	88.3%
Хэрэглээнд зориулсан зээл	949.6	66.0%	899.4	69.6%	1,534.2	53.6%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	164.0	11.4%	135.7	10.5%	591.0	20.6%
Бизнес зориулсан зээл	218.9	15.2%	172.7	13.4%	615.6	21.5%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	36.4	2.5%	20.2	1.6%	165.9	5.8%
Бусад зээл	106.4	7.4%	86.3	6.7%	212.3	7.4%
Хуулийн этгээдэд олгосон зээл	127.8	8.9%	113.0	8.8%	336.0	11.7%
Бизнесийн зээл	107.7	7.5%	101.7	7.9%	270.7	9.5%
Автомашинны зээл	1.6	0.1%	0.6	0.0%	6.2	0.2%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	3.6	0.3%	1.1	0.1%	15.2	0.5%
Бусад зээл	14.9	1.0%	9.7	0.7%	44.0	1.5%
НИЙТ	1,439.1	100.0%	1,291.7	100.0%	2,864.0	100.0%

Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2023 оны I улирлын байдлаар 39 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 19 Зээлийн ангилал

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	2,312,185,761.8	80.7%	311,504	24.0%	7,422.7
Цахим зээл	551,789,104.8	19.3%	985,521	76.0%	559.9
Нийт	2,863,974,866.6	100.0%	1,297,025	100.0%	2,208.1

2023 оны I улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 985,521 зээлдэгчийн 551.8 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 76.0 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 19.3 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 559.9 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 13.3 дахин бага байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар тогтоолоор “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-ыг баталсан. Уг журам нь Хууль зүйн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 5807 дугаарт бүртгэгдэж, [Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлийн 2022 оны 13 дугаарт](#) нийтлэгдсэнээр финтек зээл олгож байгаа ББСБ-уудын эрх зүйн орчин бүрдсэн.

Энэхүү журмын 3-т өмнө финтек зээлийн үйлчилгээ эрхэлж байсан ББСБ-ууд 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор журамд заасан шаардлагыг ханган Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхийг үүрэг болгосон.

Хүснэгт 20 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд

№	Финтек	Апп нэр
1	Ашид капитал	Simple, Simple Agent
2	Соно финтек	Sono Mongolia
3	Мобифинанс	Monpay
4	Тус финтек	TUS Fintech
5	Инвекор хэтэвч	Pocket
6	Кэйш флов финанс	tugrug app
7	Смарткапитал фанд	My Credit
8	Лэндмн	LendMN
9	Инвекор	Pocket
10	Сэндли	Hi-PayMerchant, Hipay, Sendly
11	Нөмөр кредит	numur
12	Таван богд финанс	PayOn.mn
13	Ардкредит	Ard
14	Нэт капитал финанс корпораци	Net app
15	Омни капитал	Moni Digital

16	Бизнес-Инвест девелопмент	БИД app
17	Хатан суудал инвест	Zeely
18	Ньюстар финанс	Nsf.mn, Lite+
19	Очир ундраа ОМЗ	Opay
20	ТОКИ	Toki
21	Энт кредит инвестмент	EntcreditMN
22	Гэрэлфинанс	Gerel
23	Говьфинанс	CashOne Lite, CashOne
24	Цогзолфинанс	Pocket
25	Мөнгөнзоос кредит	Pocket
26	Грийн финтек	t finance, green fintech
27	Централ капитал	kmobi
28	Жи Эс Би Капитал	GSB Prime, Mongolchat
29	Грийн-Инвестмент	Gate.mn
30	Зээл Эм Эн платформ	Zeel.mn
31	Хас хаан	XACXAAH
32	Нанокапитал	Nano Capital
33	Монголиа импакт финанс	Qmoni
34	Начин заан финанс	Naizly
35	Фин экспресс	Finex
36	Өсөх ундарга финанс	ufinance
37	Нэмэх төгрөг	Most Money
38	Онч-Энх	Ugloo
39	Жи Би Си Си	E-zeel

НИЙТ

/Pocket аппликэйшнд бүртгэлтэй 4 ББСБ байна. Зөвхөн аппликэйшнээр зээл олгож байгаа 7 ББСБ-ыг саарлаар тэмдэглэв/

Ногоон зээл

Тайлант хугацаанд 21 ББСБ 1,460 зээлдэгчид 25.7 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.0 хувийн хүүтэйгээр олгож, 24 ББСБ-ын 9,795 зээлдэгчээс 21.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны I улирлын байдлаар 28 ББСБ 8,413 зээлдэгчийн 114.8 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 4.0%-тай тэнцэж байна.


Хүснэгт 21 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 8 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	-	-	-	-	-	-
2. БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	-	-	-	-	0.1	2
3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	2.6	2	63.2	57	370.9	61
4. НОГООН БАРИЛГА	1,103.7	114	1,373.8	183	8,445.5	800
5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	-	-	49.9	2	0.1	1
6. ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ	-	-	-	-	-	-
7. ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	40.0	-	117.9	13	837.7	17
8. КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	24,572.8	1,344	20,346.7	9,540	105,162.9	7,532
Үүнээс:						
0-5 хуртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	9,451.9	377	8,317.5	3,043	44,144.3	2,807
5-10 хуртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	8,947.2	491	7,736.6	4,280	35,688.8	2,566
10-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээвэр	6,173.7	476	4,292.5	2,217	25,329.9	2,159
НИЙТ	25,719.1	1,460	21,951.4	9,795	114,817.3	8,413

Ногоон зээлийн үлдэгдлийн 91.6% буюу 105.2 тэрбум төгрөгийг карбон бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Сэргээгдэх эрчим хүч, тогтвортой ус, хаягдлын хэрэглээний салбаруудад зээлийн үлдэгдэл байхгүй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 95.7% нь хэвийн, 3.2% нь анхаарал хандуулах, 1.1% нь чанаргүй ангилалд ангилагдсан ба Ногоон барилгын салбарын зээлийн үлдэгдэл хамгийн их буюу 1.9% нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/



Бусад хөрөнгө

2023 оны I улирлын байдлаарх 306.0 тэрбум төгрөгийн бусад хөрөнгийн үлдэгдлийн 46.4% буюу 142.0 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 31.8% буюу 97.4 тэрбум төгрөг нь дансны цэвэр авлага, 21.7% буюу 66.5 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 22 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
БУСАД ХӨРӨНГӨ	306,005.0	177,643.8	210,928.1	94,345.5	36.1	300,641.6	5,363.4	30,619.5	31,924.9
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	142,015.9	72,523.3	92,919.6	48,964.9	-	140,170.8	1,845.1	12,979.9	18,839.4
-Үнэт цаасны	461.3	172.2	-	461.3	-	461.3	-	142.0	-
-Зээлийн	137,987.2	70,137.4	90,909.5	46,946.2	-	136,174.4	1,812.8	12,010.1	18,438.7
-Факторингийн	279.8	227.9	43.4	236.4	-	279.8	-	-	-
-Бусад	3,287.6	1,985.8	1,966.7	1,320.9	-	3,255.3	32.3	827.9	400.7
Авлага /цэврээр/	97,459.2	70,273.2	78,704.5	18,754.7	26.8	95,071.3	2,388.0	11,795.4	8,239.2
Нийт авлага	100,614.1	73,142.3	80,039.1	20,574.7	26.8	98,220.5	2,393.6	12,508.2	9,112.4
Хэвийн	94,193.4	69,434.9	75,920.6	18,272.7	23.3	91,845.1	2,348.3	11,590.6	8,041.6
Хугацаа хэтэрсэн	347.6	318.9	252.7	94.9	3.5	339.3	8.3	10.2	12.8
Чанаргүй:	6,073.1	3,388.5	3,865.8	2,207.0	-	6,036.0	37.1	907.4	1,057.9
-Хэвийн бус	286.5	250.0	36.5	250.0	-	254.7	31.8	5.8	2.6
-Эргэлзээтэй	2,804.0	413.4	2,390.6	413.4	-	2,804.0	-	381.8	366.8
-Муу	2,982.6	2,725.0	1,438.8	1,543.6	-	2,977.3	5.2	519.9	688.5
Нийт авлага (валютын)	67,797.8	40,944.5	47,507.8	20,289.8	26.8	65,404.2	2,393.6	12,507.1	9,112.4
Нийт авлага (төгрөгийн)	32,816.3	32,197.8	32,531.4	284.9	-	32,816.3	-	1.1	-
(Авлагын эрсдэлийн сан)	3,154.9	2,869.1	1,334.6	1,820.0	-	3,149.2	5.7	712.7	873.2
Бусад актив	66,529.9	34,847.3	39,304.0	26,626.0	9.4	65,399.6	1,130.4	5,844.2	4,846.2

Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2023 оны I улирлын байдлаар 152.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 33.7 тэрбум төгрөгийн элэгдлийг хуримтлуулж бүртгэсэн байна. Ингэснээр тайлант хугацаанд 118.3 тэрбум төгрөгийн биет ба биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 23 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	118.3	60.1	61.9	56.4	0.2	115.7	2.6	10.4	11.7
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	152.1	77.9	83.0	69.0	0.3	148.4	3.7	14.6	15.7
Барилга байгууламж	49.0	30.9	23.1	25.8	0.1	47.5	1.4	2.4	2.2
Техник хэрэгсэл	53.3	20.9	37.8	15.4	0.0	51.8	1.5	3.4	5.1
Тавилга эд хогшил	19.0	11.0	10.4	8.6	0.2	18.6	0.4	3.8	4.4
Дуусаагүй барилга	6.2	2.3	4.1	2.1	-	6.2	0.0	0.0	-
Биет бус хөрөнгө	24.5	12.8	7.6	17.0	0.0	24.3	0.2	4.9	3.9
(Хуримтлагдсан элэгдэл)	33.7	17.8	21.1	12.5	0.1	32.7	1.0	4.2	4.0
Барилга байгууламжийн	6.9	4.9	3.0	3.9	0.0	6.8	0.2	1.4	0.1
Техник хэрэгслийн	19.7	8.9	13.7	5.9	0.0	19.0	0.7	1.6	2.4
Тавилга эд хогшлын	7.1	3.9	4.4	2.7	0.1	6.9	0.2	1.2	1.5

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар буюу 729.2 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 38.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 62.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 24 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2022-I	Нийт дүнд	2023-I	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	хувь
Өр төлбөр	1,108,515.4	37.3%	1,385,731.1	37.4%	277,215.7	25.0%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	280,353.6	9.4%	398,651.7	10.8%	118,298.1	42.2%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	358,453.4	12.1%	393,562.7	10.6%	35,109.2	9.8%
Бусад эх үүсвэр	57,421.2	1.9%	48,812.7	1.3%	(8,608.5)	-15.0%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	184,504.8	6.2%	249,582.9	6.7%	65,078.1	35.3%
Төслийн эзэлийн санхүүжилт	23,938.7	0.8%	30,222.0	0.8%	6,283.3	26.2%
Бусад өр төлбөр	203,843.6	6.9%	264,899.2	7.2%	61,055.6	30.0%
Эздийн өмч	1,864,326.9	62.7%	2,316,346.7	62.6%	452,019.8	24.2%
Хувьцаат капитал	1,164,552.9	39.2%	1,361,069.5	36.8%	196,516.6	16.9%
Бусад өмч	40,000.6	1.3%	61,599.8	1.7%	21,599.3	54.0%
Сангууд	1,226.9	0.0%	1,242.2	0.0%	15.3	1.2%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	587,681.6	19.8%	816,440.2	22.1%	228,758.6	38.9%
Хоёрдогч өглөг	70,865.0	2.4%	75,995.0	2.1%	5,130.0	7.2%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	2,972,842.3	100.0%	3,702,077.8	100.0%	729,235.5	24.5%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 42.2 хувиар, ББСБ-аас гаргасан өрийн бичиг 35.3 хувиар өссөн бол өөрийн хөрөнгөөс бусад өмч 54.0 хувиар хуримтлагдсан ашиг 38.9 хувиар тус тус өссөн байна.


Сүүлийн 5 жилийн өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүдийг банкны салбартай харьцуулбал 2018 онд өөрийн хөрөнгө банкны салбарын 25.6 хувьд хүрдэг байсан бол 2023 оны I улирлын байдлаар 51.5 хувьд хүрч байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2019 оны эхний хагас жилээс 2021 оны III улирал хүртэл банкны салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийг давдаг байсан бол 2023 оны I улиралд 84.1 хувьтай тэнцэж байна. Хуримтлагдсан ашгийн хувьд өмнөх оны мөн үед 35.3 хувьтай тэнцдэг байсан бол 2023 оны I улирлаар 1.6 пунктээр өсөж 36.9 хувьтай тэнцэж байна.

Зураг 8 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг)



Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2023 оны I улирлын байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2018 оны мөн үетэй харьцуулахад 2.9 дахин өсөж 2.3 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 5.9 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 9 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Итгэлцлийн үйлчилгээний өглөг

2023 оны I улирлын байдлаар өр төлбөрөөс хамгийн өндөр өсөлтийг итгэлцлийн үйлчилгээний өглөг үзүүлсэн байна. Өмнөх оны мөн үеэс 42.2% буюу 118.3 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 69 ББСБ-аас 61 ББСБ 7,088 итгэмжлэгчээс 398.7 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 10 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



Улаанбаатар хотын 60 ББСБ 7,084 итгэмжлэгчээс 293.0 тэрбум төгрөг, хөдөө орон нутгийн 1 ББСБ 4 итгэмжлэгчээс 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 25 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	398.7	104.8	293.9	397.4	1.3	141.8	256.8	104.3
-Төгрөгөөр	328.1	100.1	228.0	326.8	1.3	104.5	223.6	104.3
-Валютаар	70.5	4.7	65.8	70.5	-	37.3	33.2	86.0
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	69	49	20	68	1	5	64	7
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	61	42	19	60	1	5	56	6
Нийт итгэмжлэгчдийн тоо	7,088	2,117	4,971	7,084	4	2,609	4,479	295

Хамгийн өндөр дүнгээр буюу 88.3 тэрбум төгрөгийг 197 итгэмжлэгчээс татан төвлөрүүлсэн бол хамгийн олон буюу 1,897 итгэмжлэгчээс дунджаар 7.6 сая төгрөг нийт 14.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Нэг итгэмжлэгчээс дунджаар хамгийн өндөр дүнгээр 3.8 тэрбум төгрөгийг татсан байна.

Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2023 оны I улирлын байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 9.8 хувиар өсөж, 97 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 393.6 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 26 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн 393.6	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл 309.2	Уламжлалт 191.0	Финтек 202.5	УБ 391.7	ХОН 1.9	ХК 70.7	ХХК 322.9	ГХО 76.4
Хугацаагаар:										
Богино хугацаат зээл	157.6	40.1%	126.3	106.7	50.9	157.3	0.3	17.3	140.4	22.6
Урт хугацаат зээл	235.9	59.9%	182.9	84.3	151.6	234.3	1.6	53.4	182.5	53.8
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	307.3	78.1%	246.2	141.0	166.4	305.4	1.9	53.2	254.1	44.4
Валютаар	86.2	21.9%	63.0	50.1	36.2	86.2	-	17.5	68.8	32.0
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	314.2	79.8%	252.6	141.7	172.6	312.3	1.9	59.4	254.8	48.2
Зээл /төгрөгөөр/	307.3	78.1%	246.2	141.0	166.4	305.4	1.9	53.2	254.1	44.4
Зээл /валютаар/	6.9	1.7%	6.5	0.7	6.2	6.9	-	6.2	0.7	3.9
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	79.3	20.2%	56.6	49.4	30.0	79.3	-	11.3	68.1	28.2

Бусад эх үүсвэр

2023 оны I улирлын байдлаар 18 ББСБ 48.8 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс нэр бүхий 7 ББСБ 4.8 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 3 ББСБ 8.7 сая төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 7 ББСБ 12.6 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй, нэр бүхий 1 ББСБ 22.7 тэрбум төгрөгийн гадаад валютын арилжааны эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 27 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХК
Нийт	48,812.7	100.0%	36,620.9	32,853.8	15,958.9	48,812.7	690.7
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	4,832.0	9.9%	4,708.8	2,930.2	1,901.8	4,832.0	690.7
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	8,700.6	17.8%	8,565.7	134.9	8,565.7	8,700.6	-
Факторингийн үйлчилгээний өглөг	12,576.5	25.8%	642.9	7,085.1	5,491.4	12,576.5	-
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	22,703.6	46.51163%	22,703.6	22,703.6	-	22,703.6	-

Өмнөх оны мөн үеэс мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 70.5 хувиар, факторингийн үйлчилгээний өглөг 69.1 хувиар тус тус буурсан байна. Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 53.9 дахин нэмэгдсэн ба 1 ББСБ-ын өглөг 98.5 хувийг бүрдүүлж байна.

Зураг 11 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	2019-I	2020-I	2021-I	2022-I	2023-I
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр	-	-	-	51,000.0	-
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,545,088.9	6,178,955.0	3,753,541.3	16,370,513.9	4,832,041.5
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	3,694,563.2	1,173,253.0	5,709,078.5	161,526.0	8,700,593.8
Факторингийн үйлчилгээний өглөг	8,134,245.2	5,904,191.7	35,999,141.4	40,671,419.3	12,576,477.0
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	166,772.5	22,703,582.2
Нийт	14,373,897.3	13,256,399.8	45,461,761.2	57,421,231.7	48,812,694.5

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа болон гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

ББСБ-аас гаргасан өрийн бичиг


2023 оны I улирлын байдлаар 41 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 1,615 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 249.6 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 28 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	249,582.9	185,217.8	36,545.2	213,037.7	248,969.8	613.1	64,567.1	185,015.9	41,324.8
Төгрөгөөр	237,835.0	173,558.0	36,457.2	201,377.9	237,221.9	613.1	64,567.1	173,268.0	41,324.8
Валютаар	11,747.9	11,659.8	88.1	11,659.8	11,747.9	-	-	11,747.9	-


Өрийн бичгийн үлдэгдэл 2018 оны мөн үеэс 25.2 дахин өсөж 249.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 12 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 7.1 хувь байсан бол 2023 оны I улирлын 2.4 пунктээр буурч 4.7 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 29 Өрийн бичиг /валютаар/



“Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам” Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаанд буюу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хэрэгжсэн тул 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн ББСБ-ууд өрийн бичиг гаргахдаа “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллана.

ҮЦГ-аас олон нийгэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ 91.1 тэрбум төгрөгийн өрийн хэрэгсэл гаргах зөвшөөрөл авсан бол, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 995 дугаар тогтоолоор баталсан “[Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам](#)”-ын дагуу 21 ББСБ 158,563,910,000.0 төгрөгийн өрийн бичиг гаргасан байна.

Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 13 ББСБ 30.2 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 30 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	30,222.0		14,377.5	24,652.5	5,569.5	28,713.8	1,508.2	5,569.5	24,652.5	8,540.1
Хугацаагаар										
Богино хугацаат	8,106.4	26.8%	3,999.3	4,132.1	3,974.3	7,880.4	226.0	3,974.3	4,132.1	-
Урт хугацаат	22,115.5	73.2%	10,378.2	20,520.3	1,595.2	20,833.4	1,282.2	1,595.2	20,520.3	8,540.1
Төрлөөр										
Засгийн газрын	-	-	-	-	-	-	-	-	-	-
Гадаадын	12,989.7	43.0%	12,109.5	7,420.2	5,569.5	12,989.7	-	5,569.5	7,420.2	6,540.1
Дотоодын	6,272.4	20.8%	2,267.9	6,272.4	-	4,849.2	1,423.2	-	6,272.4	2,000.0
Бусад	10,959.9	36.3%	-	10,959.9	-	10,874.9	85.0	-	10,959.9	-
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	25,357.0	83.9%	10,920.8	19,787.5	5,569.5	23,848.8	1,508.2	5,569.5	19,787.5	5,083.4
Валютаар	4,865.0	16.1%	3,456.7	4,865.0	-	4,865.0	-	-	4,865.0	3,456.7

Бусад өр төлбөр

2023 оны I улирлын байдлаар 478 ББСБ 265.0 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 16.8% буюу 44.4 тэрбум төгрөг нь 78 ББСБ-ын хуримтлуульж тооцсон хүүгийн өглөг, 83.2% буюу 220.4 тэрбум төгрөг нь 478 ББСБ-ын бусад пассивын үлдэгдэл байна.

Хүснэгт 31 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Хуримтлуульж тооцсон хүүгийн өглөг	44,443.1	32,333.9	11,175.7	33,267.4	147.7	44,421.9	21.2	10,451.7	33,991.4	6,815.1
Ангиллаар										
Эзэлийн	21,348.9	12,554.4	8,072.7	13,276.2	147.7	21,342.9	6.0	3,529.5	17,819.4	1,473.6
Үнэт цаасны	3,448.7	3,408.6	127.6	3,321.1	-	3,448.7	-	1,175.4	2,273.4	679.6
Бусад	19,645.5	16,370.8	2,975.4	16,670.1	-	19,630.3	15.2	5,746.9	13,898.6	4,661.9
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	40,439.2	28,615.0	10,009.3	30,429.9	147.7	40,418.0	21.2	9,172.8	31,266.4	5,647.6
Валютаар	4,004.0	3,718.9	1,166.4	2,837.5	-	4,004.0	-	1,278.9	2,725.0	1,167.6
Бусад пассив	220,456.0	132,046.9	112,504.4	107,661.1	881.2	218,093.7	2,362.3	54,351.8	166,104.2	45,897.7

Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.9% буюу 196.5 тэрбум төгрөгөөр өсөж 1.4 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь нийт пассивын 36.8 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 32 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/

Хувьцаат капитал	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Хувьцаат капитал	1,361,069.5	418,536.8	1,040,437.7	315,831.9	17,545.4	1,307,609.0	53,460.6	40,299.9	1,320,769.6	106,028.0
Энгийн хувьцаа	1,363,424.2	421,054.8	1,040,454.8	318,169.5	17,545.4	1,310,006.0	53,418.3	42,641.1	1,320,783.1	105,910.5
Давуу эрхтэй хувьцаа	193.3	30.0	193.3	-	-	151.0	42.3	-	193.3	121.0
Халаасны хувьцаа	2,548.0	2,548.0	210.4	2,337.6	-	2,548.0	-	2,341.2	206.8	3.6

Хувьцаат капиталын хэмжээ 2019 оны мөн үеэс 1.6 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт, үүнээс энгийн хувьцаа 1.6 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт, давуу эрхийн хувьцаа 3.3 дахин буурч 193.3 сая төгрөгт, халаасны хувьцаа 12.3 дахин өсөж 2.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2023 оны I улирлын байдлаар 514 ББСБ-ын 1.4 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 3 ББСБ-ын 193.3 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 4 ББСБ-ын 2.5 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 13 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 384 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 95.7% буюу 1.3 их наяд

төгрөг байна. Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 130 ББСБ-ын 58.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 4.3 хувийг бүрдүүлж байна.

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 268.9 тэрбум төгрөг байгаа нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 19.8 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 1.0 их наяд төгрөг байгаа нийт дүнгийн 75.2 хувийг бүрдүүлж байгаа зэргээс харахад томоохон ББСБ-ууд бусдаас хөрөнгө татан төвлөрүүлж үйл ажиллагаагаа явуулж байгаа тул хяналт шалгалтыг сайжруулах нь зүйтэй.

Хүснэгт 33 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	411.6	32	30.2%	6.2%	7.3	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	698.3	253	51.3%	49.2%	2.5	1	7.0	2	3.0	1
1.9-2.5 тэрбум	192.7	99	14.2%	19.3%	-	-	1.9	1	-	-
1.4-1.9 тэрбум	16.8	12	1.2%	2.3%	2.8	2	4.2	3	1.4	1
0.6-1.4 тэрбум	17.0	21	1.2%	4.1%	7.8	11	5.3	6	2.9	3
0.6 тэрбум хүртэлх	24.8	97	1.8%	18.9%	0.5	1	14.0	65	10.3	31
НИЙТ	1,361.1	514	100.0%	100.0%	20.8	16	32.4	77	17.5	36

Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 54.0 хувиар өсөж 21.6 тэрбум төгрөгт, сангууд 1.2 хувиар өсөж 1.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 34 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/


	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Бусад өмч	61,599.8	55,378.9	15,654.5	45,940.2	86.9	61,293.9	305.9	53,281.1	8,318.8	39,288.8
Нэмж төлөгдсөн капитал	56,907.5	53,680.2	12,691.6	44,215.9	51.8	56,768.4	139.0	52,994.3	3,913.2	39,283.9
Дахин үнэлгээний нэмэгдэл	2,684.3	957.3	1,725.5	953.7	-	2,647.6	36.7	229.4	2,454.9	4.9
Хандивын капитал	2,008.0	741.3	1,237.4	770.6	35.0	1,877.8	130.2	57.3	1,950.7	-
Сангууд	1,242.2	115.3	1,217.1	25.1	-	393.3	848.9	24.9	1,217.2	16.9
Нөөцийн сан	652.4	72.5	652.3	0.1	-	79.1	573.3	-	652.4	14.9
Нийгмийн хөгжлийн сан	589.8	42.8	564.8	25.0	-	314.2	275.6	24.9	564.9	2.0

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 38.9% буюу 228.8 тэрбум төгрөгөөр өсөж 816.4 тэрбум төгрөгт хүрчээ.

Тайлант хугацаанд 428 ББСБ 102.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 10 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 76 ББСБ 2.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 35 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/




Хоёрдогч өглөг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хоёрдогч өглөгийн хэмжээ 7.2 хувиар өсөж 76.0 тэрбум төгрөгт хүрчээ. 2023 оны I улирлын байдлаар 8 ББСБ 76.0 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.

Ашигт ажиллагаа

2023 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 258.5 тэрбум төгрөгийн орлого олж, 159.0 тэрбум төгрөгийн зардал гаргаж 99.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 14 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 40.2% буюу 74.1 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 50.3% буюу 53.2 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 26.6% буюу 20.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 36 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/

ОРЛОГО	2022-I	2023-I	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	145,573,448.5	210,349,273.7	81.4%	64,775,825.2	44.5%
Хүүгийн бус орлого	32,384,710.8	40,773,740.6	15.8%	8,389,029.7	25.9%
-Санхүүгийн үйлчилгээний орлого	22,206,016.4	29,010,297.3	11.2%	6,804,280.9	30.6%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	1,350.0	162.8	0.0%	-1,187.2	-87.9%
- Мөнгөн гүйвүүлгын орлого	530,639.3	1,037,080.4	0.4%	506,441.1	95.4%
- Картын үйлчилгээний орлого	-	-	-	-	-
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	25,190.6	-	-	-25,190.6	-100%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	16,565,715.8	15,733,435.3	6.1%	-832,280.5	-5.0%
- Бусад	5,083,120.7	12,239,618.7	4.7%	7,156,498.0	140.8%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6,254,577.9	7,335,625.0	2.8%	1,081,047.1	17.3%
Ердийн бус орлого	172,068.9	80,165.4	0.0%	-91,903.5	-53.4%
НИЙТ ОРЛОГО	184,384,806.2	258,538,804.7	100.0%	74,153,998.5	40.2%
ЗАРДАЛ					
Хүүгийн зардал	19,522,729.4	29,056,832.9	18.3%	9,534,103.5	48.8%
Хүүгийн бус зардал	66,649,357.7	91,626,125.4	57.6%	24,976,767.7	37.5%
Болзошгүй эрсдэлийн зардал	12,164,362.3	27,395,991.6	17.2%	15,231,629.3	125.2%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,473,208.9	1,813,593.8	1.1%	340,384.8	23.1%
Орлогын албан татварын зардал	5,937,017.6	9,072,512.6	5.7%	3,135,494.9	52.8%
Ердийн бус зардал	22,658.2	9,321.5	-	-13,336.8	-58.9%
НИЙТ ЗАРЛАГА	105,769,334.2	158,974,377.7	100.0%	53,205,043.6	50.3%
АШИГ					
ЦЭВЭР АШИГ	78,615,472.1	99,564,427.0	100.0%	20,948,954.9	26.6%

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд бусад орлого 2.4 дахин буюу 7.1 тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнд нэр бүхий 2 ББСБ-ын бусад орлого 5.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь болзошгүй эрсдэлийн зардал болон итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан зардал байна.

Хүснэгт 37 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/


ОРЛОГО	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хүүгийн орлого	210,349.3	134,374.1	96,488.4	113,394.1	19.0	206,458.3	3,891.0	33,415.4	29,414.7
Хүүгийн бус орлого	40,773.7	27,190.0	17,594.1	23,178.6	1,520.0	40,370.3	403.4	6,998.3	2,101.2
- Санхүүгийн үйлчилгээний орлого	29,010.3	19,481.1	11,135.0	17,874.3	-	28,638.1	372.2	6,287.7	1,387.7
<i>Итгэлцлийн үйлчилгээний орлого</i>	0.2	0.2	-	0.2	-	0.2	-	-	-
<i>Мөнгөн гуйвуулгын орлого</i>	1,037.1	919.4	816.7	220.4	-	1,037.1	-	220.4	-
<i>Картын үйлчилгээний орлого</i>	-	-	-	-	-	-	-	-	-
<i>Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого</i>	-	-	-	-	-	-	-	-	-
<i>Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого</i>	15,733.4	12,918.7	2,640.9	13,091.5	-	15,391.8	341.6	5,744.3	1,054.9
<i>Бусад</i>	12,239.6	5,642.8	7,677.4	4,562.2	-	12,209.1	30.6	323.0	332.8
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	7,335.6	4,330.3	5,713.8	1,621.9	-	7,137.3	198.3	1,020.2	1,105.2
Ердийн бус орлого	80.2	16.3	80.0	0.1	-	80.1	0.0	-	-
НИЙТ ОРЛОГО	258,538.8	165,910.7	119,876.4	138,194.7	1,538.9	254,046.0	4,492.8	41,434.0	32,621.2
ЗАРДАЛ									
Хүүгийн зардал	29,056.8	21,321.1	10,770.0	18,286.8	-	28,921.4	135.4	5,180.0	3,699.0
Хүүгийн бус зардал	91,626.1	62,751.1	37,240.7	54,070.0	806.9	90,070.7	1,555.4	18,822.5	15,462.5
Болзошгүй эрсдэлийн зардал	27,396.0	18,059.8	9,363.3	17,973.6	-	27,193.6	202.4	4,857.1	3,497.1
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,813.6	1,089.1	1,000.2	813.3	0.1	1,698.9	114.7	182.7	182.0
Орлогын албан татварын зардал	9,072.5	6,088.7	4,365.0	4,706.6	24.7	8,965.4	107.1	1,758.2	1,030.9
Ердийн бус зардал	9.3	-	9.3	-	-	3.3	6.0	-	-
НИЙТ ЗАРЛАГА	158,974.4	109,309.7	62,748.5	95,850.3	831.7	156,853.3	2,121.0	30,800.4	23,871.4
АШИГ									
ЦЭВЭР ОРЛОГО	99,564.4	56,601.0	57,127.9	42,344.4	707.2	97,192.7	2,371.7	10,633.6	8,749.7

Зээлийн эрсдэлийн сангийн зардал 94.3 хувиар өссөн нь Болзошгүй эрсдэлийн зардлын өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн (нөлөө 98.9%) байна. Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан зардал өмнөх оны мөн үеэс 99.6 хувиар өсөж 16.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Гадаад валютын арилжааны мэдээ


Тайлант хугацаанд буюу 2023 оны I улиралд гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 139 ББСБ-аас 76.3% буюу 106 ББСБ-аас ирүүлсэн тайлангаар 1,005.3 тэрбум төгрөгийн валют худалдан авсан нь банкны салбартай харьцуулахад 11.0 хувьтай тэнцэж байгаа бол 972.2 тэрбум төгрөгийн валют зарсан нь банкны салбартай харьцуулахад 10.7 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 38 2023 оны I улирлын байдлаарх валют арилжааны мэдээ /тэрбум төгрөгөөр/



ББСБ-уудын ирцийн мэдээ сүүлийн 5 жилийн байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 39 Гадаад валютын арилжааны мэдээ /2023 оны I улирал/



Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2023 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 514 ББСБ-ын 90.1% буюу 463 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 9.9% нь буюу 51 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 44 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 4 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 22 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 40 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /69 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /409 ББСБ/		ЗГВА /36 ББСБ/		Нийт /514 ББСБ/		
		√	X	√	X	√	X	√	X	
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	69	-	407	2	36	-	512	2	
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	69	-	407	2	36	-	512	2	
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	69	-	407	2	36	-	512	2	
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	66	3	408	1	36	-	510	4	
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)	65	4	395	14	36	-	496	18	
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	69	-	401	8	XXX		506	8	
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	69	-	408	1			513	1	
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	69	-	408	1			513	1	
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	69	-	405	4			510	4	
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	69	-	409	-			514	-	
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	69	-	409	-			514	-	
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “П” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	69	-	409	-			514	-	
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	69	-	409	-			514	-	
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	68	1	407	2			511	3	
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	69	-	404	5			509	5	
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	68	1	XXX				513	1	
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	69	-	409	-			514	-	
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	68	1	399	10		36	-	503	11

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо
X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 18 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 11 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 8 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 5 ББСБ буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 4 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

Дүгнэлт

2023 оны I улирлын байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 514 ББСБ-аас 509 ББСБ тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 4 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 1 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2023 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 28,353 хувьцаа эзэмшигчдийн 514 ББСБ, 428 салбар нэгж, 7 төлөөлөгчийн газар, 4,735 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.9 сая харилцагч, 1.3 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар өсөж, банкны салбарын 8.0%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 84.1%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.9 пунктээр өссөн дүн юм.

2023 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар буюу 729.2 тэрбум төгрөгөөр өсөж 3.7 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 78.2 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 38.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 62.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 24 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 29 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 14 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт бүртгэсэн дүн байхгүй байна. Иймээс 15 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.9% буюу 570.4 тэрбум төгрөгөөр өсөж 2023 оны I улирлын байдлаар 2,864.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 165.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,698.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Нийт зээлийн үлдэгдлийн 87.6 хувийг буюу 2.5 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4.4 хувийг буюу 125.9 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 8.0 хувийг буюу 228.0 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр буурсан бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.5, 0.4 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 353.9 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 46.7%-д буюу 165.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар буюу 729.2 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 25.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 24.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өглөг 42.2 хувиар, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 9.8 хувиар, ББСБ-аас гаргасан өрийн бичгийн үлдэгдэл 35.3 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 26.2 хувиар тус тус өссөн байгаа нь ББСБ-уудын хувьд бусдаас өртөг бүхий эх үүсвэрийг татан төвлөрүүлж байгааг харуулж байна.

Ашигт ажиллагаа

2023 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 258.5 тэрбум төгрөгийн орлого олж, 159.0 тэрбум төгрөгийн зардал гаргаж 99.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 40.2% буюу 74.1 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 50.3% буюу 53.2

тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 26.6% буюу 20.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2023 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 514 ББСБ-ын 90.1% буюу 463 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна. Нийт ББСБ-уудын 9.9% нь буюу 51 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна.

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 18 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 11 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 8 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 5 ББСБ буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 4 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР